



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага.....	17
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг





Г
БӨМБӨГӨР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Д.ОЮУНДАЛАЙ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/36

танай _____-ны № _____-т

Г _____ Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 854,636.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 777,054,6 мянган төгрөг, төсөвт 5.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 83.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 30,928.5 мянган төгрөгийн авлагатай. Эмийн өглөг, ХХАОТ-ы өглөг бусад өглөг 60,012.1 мянган төгрөг байна.

Аудитын гол асуудал

5020157

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдсэн, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, газар эзэмших эрхийн зөрчилтэй байгаа нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд 7 зорилтын 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллага 90,0 хувьтай дүгнэсэн байна.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,958,330.78	73,001,345.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	74,405.50	83,293.39
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	74,405.50	83,293.39
31210	Төгрөг	74,405.50	83,293.39
31211	Төрийн сангийн харилцах	74,405.50	83,293.39
33	АВЛАГА	1,037,557.72	31,713,202.86
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,037,557.72	784,703.86
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	30,928,499.00
34	УРЬДЧИЛГАА	9,004.00	9,004.00
34710	Урьдчилгаа тооцоо	9,004.00	9,004.00
34713	Цалингийн урьдчилгаа	9,004.00	9,004.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,837,363.56	41,195,845.56
35100	Түүхий эд материал	42,107,413.56	27,691,765.56
35110	Тусгай зориулалттай материал	15,273,789.00	11,447,316.20
35130	Эм боох материал	26,833,624.56	16,244,449.36
35400	Хангамжийн материал	11,729,950.00	13,504,080.00
35410	Бичиг хэргийн материал	215,000.00	195,000.00
35420	Аж ахуйн материал	11,283,950.00	13,290,680.00
35460	Хүнсний материал	231,000.00	18,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	577,794,986.97	521,656,438.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	577,794,986.97	521,656,438.06
39200	Биет хөрөнгө	566,868,986.97	510,840,438.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	394,303,921.00	394,303,921.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-75,436,283.83	-97,659,248.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,170,000.00	43,025,625.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,360,000.00	-38,181,484.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	331,232,427.04	346,108,627.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	-141,505,462.95	-204,728,678.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,400,455.00	78,950,455.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,347,569.29	-33,373,611.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,800,000.00	21,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0	-1,016,666.63
39217	Ном	1,611,500.00	1,611,500.00
39300	Биет бус хөрөнгө	10,926,000.00	10,815,999.96
39301	Програм хангамж	890,000.00	890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-560,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	10,486,000.00	10,486,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	632,753,317.75	594,657,783.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	60,012,128.78
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	60,012,128.78
41300	Өглөг	0	60,012,128.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	13,884,570.78
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	41,752,058.00
41360	Бусад өглөг	0	4,375,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	4,375,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	632,753,317.75	534,645,655.09
51	Засгийн газрын хувь оролцоо	632,753,317.75	534,645,655.09
51100	Засгийн газрын оруулсан капитал	326,681,036.00	326,681,036.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	326,681,036.00	326,681,036.00


Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51200	Хуримтлагдсан үр дүн	174,289,335.11	76,181,672.45
51210	Өмнөх үеийн үр дүн	-317,656,828.52	174,289,335.11
51220	Тайлант үеийн үр дүн	491,946,163.63	-98,107,662.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,782,946.64	131,782,946.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	632,753,317.75	594,657,783.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	883,472,055.08	852,089,803.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,562,702.18	94,092,790.06
120	Нийтлэг татварын бус орлого	67,562,702.18	94,092,790.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,801,212.90	50,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,801,212.90	50,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	35,672,489.12	8,531,925.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	31,890,213.06	35,560,865.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	815,909,352.90	757,997,013.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,552,800.00	54,471,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,552,800.00	54,471,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	776,555,340.00	703,525,913.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	776,555,340.00	703,525,913.82
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	930,211,425.09	950,197,466.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	930,211,425.09	950,197,466.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	930,207,719.09	950,192,417.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	412,993,356.00	498,427,532.25
210101	Үндсэн цалин	412,993,356.00	498,427,532.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,833,784.97	62,870,985.32
210201	Тэтгэврийн даатгал	51,833,784.97	62,870,985.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,484,910.93	51,952,651.24
210301	Гэрэл, цахилгаан	3,620,410.93	3,041,451.24
210302	Түлш, халаалт	33,587,500.00	48,911,200.00
210303	Цэвэр, бохир ус	277,000.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	54,141,590.00	80,371,021.25
210401	Бичиг хэрэг	14,519,600.00	5,828,350.00
210402	Тээвэр, шатахуун	37,520,990.00	37,508,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,000.00	5,008,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	85,000.00	4,453,600.00
210408	Бараа материал акталсны зардал	0	25,592,591.25
2105	Нормативт зардал	204,127,942.10	110,988,633.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	177,123,694.10	96,354,913.81
210502	Хоол, хүнс	25,179,648.00	14,633,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,824,600.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,536,200.00	26,009,000.00
210604	Урсгал засвар	4,536,200.00	26,009,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,893,000.00	1,750,000.00
210702	Дотоод албан томилолт	1,893,000.00	1,750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,650,662.90	3,453,760.00



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,350,662.90	3,344,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	60,400.00
210807	Газрын төлбөр	0	49,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,546,272.19	114,368,833.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,273,248.00	14,948,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,273,024.19	99,420,373.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,706.00	5,048.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,706.00	5,048.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,706.00	5,048.76
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-46,739,370.01	-98,107,662.66
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-20,417,386.40	0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	20,417,386.40	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-67,156,756.41	-98,107,662.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,129,271,852.90	777,068,514.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,801,212.90	50,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,801,212.90	50,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,801,212.90	50,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,801,212.90	50,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,127,470,640.00	727,068,514.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,552,800.00	54,471,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,552,800.00	54,471,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,089,917,840.00	672,597,414.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,089,917,840.00	672,597,414.82
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,007,137,647.40	761,959,726.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,007,137,647.40	761,959,726.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,007,133,941.40	761,954,678.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	397,876,548.20	483,250,392.93
210101	Үндсэн цалин	228,634,337.20	299,826,930.71
210102	Нэмэгдэл	118,410,832.00	133,674,752.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,299,547.00	4,524,735.77
210104	Урамшуулал	43,531,832.00	45,223,974.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,079,180.00	63,910,700.00
210201	Тэтгэврийн даатгал	34,716,480.00	43,458,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,090,700.00	5,113,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,272,500.00	4,090,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	818,100.00	1,022,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,181,400.00	10,225,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,849,094.00	51,968,651.24
210301	Гэрэл, цахилгаан	4,029,794.00	3,838,951.24
210302	Түлш, халаалт	33,419,900.00	47,329,700.00
210303	Цэвэр, бохир ус	399,400.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,739,920.00	41,801,730.00

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	8,579,200.00	3,961,850.00
210402	Тээвэр, шатахуун	30,022,090.00	26,267,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,980,000.00
210404	Ном, хэвлэл	348,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,139,630.00	2,918,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,671,000.00	6,673,980.00
2105	Нормативт зардал	96,630,421.20	58,430,364.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,673,251.20	46,952,644.00
210502	Хоол, хүнс	17,593,840.00	11,477,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,363,330.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,065,400.00	32,847,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,082,000.00	17,999,600.00
210602	Тавилга	0	450,000.00
210604	Урсгал засвар	2,983,400.00	14,397,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,893,000.00	1,750,000.00
210702	Дотоод албан томилолт	1,893,000.00	1,750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	311,487,500.00	10,833,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	309,592,000.00	10,724,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	233,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,500.00	60,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	325,000.00	0
210807	Газрын төлбөр	0	49,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,512,878.00	17,161,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,512,878.00	17,161,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,706.00	5,048.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,706.00	5,048.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,706.00	5,048.76
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	122,134,205.50	15,108,787.89
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	122,059,800.00	15,099,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	122,059,800.00	15,099,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	122,059,800.00	15,099,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	122,059,800.00	15,099,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-122,059,800.00	-15,099,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	74,405.50	8,887.89
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	74,405.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	74,405.50	83,293.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцоогийн нийт дүн
1	2022 оны 01-р сарын 11-нээрх үлдэгдэл	316,195,036.00	56,224,214.00	(61,686,867.00)	310,732,383.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,195,036.00	56,224,214.00	-61,686,867.00	310,732,383.00
4	Тайлант үеийн үр дүн	0	0	-8,943,877.14	-8,943,877.14
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	174,289,335.11	632,753,317.75
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	174,289,335.11	632,753,317.75
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	174,289,335.11	632,753,317.75
8	Тайлант үеийн үр дүн	0	0	-98,107,662.66	-98,107,662.66
9	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	76,181,672.45	534,645,655.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	854,543,400.00	777,054,578.17	77,488,821.83	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,543,400.00	777,054,578.17	77,488,821.83	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854,543,400.00	777,054,578.17	77,488,821.83	90.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,309,900.00	483,250,392.93	33,059,507.07	93.6
210101	Үндсэн цалин	306,998,100.00	299,826,930.71	7,171,169.29	97.7
210102	Нэмэгдэл	159,625,300.00	133,674,752.27	25,950,547.73	83.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	710,000.00	4,524,735.77	-3,814,735.77	0.0
210104	Урамшуулал	48,976,500.00	45,223,974.18	3,752,525.82	92.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,817,900.00	63,910,700.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	43,366,100.00	43,458,900.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,113,100.00	5,113,100.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,090,900.00	4,090,900.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,022,500.00	1,022,500.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,225,300.00	10,225,300.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,971,100.00	51,968,651.24	2,448.76	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,841,000.00	3,838,951.24	2,048.76	99.9
210302	Түлш, халаалт	47,330,100.00	47,329,700.00	400.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,415,500.00	41,801,730.00	3,613,770.00	92.0
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,961,850.00	38,150.00	99.0
210402	Тээвэр, шатахуун	28,635,100.00	26,267,000.00	2,368,100.00	91.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,400.00	1,980,000.00	400.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,124,700.00	2,918,900.00	1,205,800.00	70.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,675,300.00	6,673,980.00	1,320.00	100.0
2105	Нормативт зардал	94,485,100.00	58,430,364.00	36,054,736.00	61.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,340,700.00	46,952,644.00	32,388,056.00	59.2
210502	Хоол, хүнс	15,144,400.00	11,477,720.00	3,666,680.00	75.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,400,000.00	47,246,900.00	2,153,100.00	95.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	17,999,600.00	400.00	100.0
210602	Тавилга	15,500,000.00	14,849,900.00	650,100.00	95.8
210604	Урсгал засвар	15,900,000.00	14,397,400.00	1,502,600.00	90.5
2107	Томилот, зочны зардал	1,750,000.00	1,750,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилот	1,750,000.00	1,750,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,263,400.00	10,833,960.00	429,440.00	96.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,728,400.00	10,724,500.00	3,900.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	0	250,000.00	0.0

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	60,400.00	19,600.00	75.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	0	55,000.00	0.0
210807	Газрын төлбөр	150,000.00	49,060.00	100,940.00	32.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,130,500.00	17,861,880.00	2,268,620.00	88.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,130,500.00	17,861,880.00	2,268,620.00	88.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	854,543,400.00	777,068,424.82	77,474,975.18	90.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,471,100.00	54,471,100.00	0.00	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	54,471,100.00	54,471,100.00	0.00	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	749,997,900.00	672,597,324.82	77,400,575.18	89.7
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	749,997,900.00	672,597,324.82	77,400,575.18	89.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,074,400.00	50,000,000.00	74,400.00	99.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	50,000,000.00	0.00	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	74,400.00	0	74,400.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	74,405.50	-74,405.50	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	83,293.39	-83,293.39	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0	0.00	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	36	36	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар “хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх” хүрээнд үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлсон байна.

Тус байгууллага нь Хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар хүртээмжтэй үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт тавин ажилласан байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд Эрүүл мэндийн төв нь 24 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант оны байдлаар нийт хэвтэн эмчлүүлэгсэд 415, дундаж ор хоног 6.5 хувь. эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 6784 хүн хамрагдаж үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 2389 хүн хамрагдсан эмчлүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Эрүүл мэндийн төвийн дарга Д.Оюундалай, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Гандалай нар зурж, нярваар Т.Оюунтөгс нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин



Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм эмнэлэгийн хэрэгсэлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,095,6 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	74,4	83,2	8,8
Авлага	1,046,5	31,722,2	30,675,7
Бараа материал	53,837,3	41,195,8	-12,641,5
Үндсэн хөрөнгө	853,894,3	897,176,1	43,281,8
Хуримтлагдсан элэгдэл	-276,099,3	-375,519,6	-99,510,3
Нийт хөрөнгө	632,753,3	594,657,7	-38,095,6
Өр төлбөр		60,012,1	60,012,1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	632,753,3	534,645,6	-98,107,7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	632,753,3	594,657,7	-38,095,6

Эх сурвалж: Бөмбөгөр сумын эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өглөгийн дансууд байна.

Тайлант оны эхэнд 74.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 83.2 мянган төгрөг өмнөх оноос 8.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 240,991.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 16,560.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 270,194.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж бараа материалын үлдэгдэл 12,641.5 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан байна.

Тайлант онд авлага 30.675.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМД сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага 30,928.5 мянган төгрөг байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 15,749.9 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 5,676.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар 2855.6 мянган төгрөгийн мотоциклийг тээврийн хэрэгслийн дансанд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19,000.0 мянган төгрөгийн гадна тохижилт, засвар хийгдэж нийт 43,281.8 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.


Тайлант онд өглөг 60,012.1 мнган төгрөгөөр нэмэгдсэн Тун хурх фарм ХХК-д 20,683.5 мянга, Эрүүл мэндийн газарт 3,224.8 мянга, Монфа трейд ХХК-д 1,141.1 мянга, Монбийфарм ХХК-д 830.0 мянга, Еврофарм ХХК-д 1,256.0 мянга, нийт эмийн үнэ 36,848.3 мянган төгрөг, ХАОТатварт 13,676.7 мянга, хоолны төлбөрт 2,943.4 мянга, бусад байгууллагад төлөх бараа, шатахууны өглөг 5,875.5 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 38,095.6 мянган төгрөгөөр буурч, 594,657.7 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 38,095.6 мянган төгрөгөөр буурч 594,657.7 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 862,474.8 мянга төгрөг, орон нутгийн төсвөөс 48,724.3 мянган төгрөг нийт 910,749.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс 203,029.8 мянган төгрөгөөр бууруулан 707,719.3 мянган төгрөгөөр батласан байна.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлэхтэй холбоотой 3 удаа төсөвт өөрчлөлт оруулж 804,469.4 мянган төгрөгөөр тодотгож Эрүүл мэндийн яамнаас 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилт нэмж олгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас гүйцэтгэлээр 749,997.9 мянган төгрөг санхүүжилтийн төлөвлөгөө батлагдсан урьд оны санхүүжилтийн үлдэгдлээс 74.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 54,471.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 854,543.4 мянган төгрөгийн санхүүжилтийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 777,054.6 мянган төгрөгийг зарцуулж, 83.3 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 54,471.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.9 хувь буюу 54,466.0 мянган төгрөгийг зарцуулж 5.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Хөтөлбөр 71602 Эмнэлэгийн тусламж үйлчилгээ				
1	80112 Нийтлэг үйлчилгээ	54,471,100.00	54,466,051.24	5,048.8	99.99%
2	80302 Нэг иргэнд ноогдох нормативт зардал	523,939,700.00	500,307,931.32	23,631,768.7	95.49%
3	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	226,132,600	172,280,595.61	53,852,004.4	76.19%
4	813603 Дээд шатны төсвөөс хувиарьласан нэмэлт санхүүжилт	50,000,000	50,000,000.0	0.0	100.00%
	ДҮН	854,543,400.00	777,054,578.17	77,488,821.8	90.93%

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд бараа материалын дансанд 240,991.9 мянган төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд 15,749.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Үүнээс Баянхонгор аймгийн

Эрүүл мэндийн газраас эм боох материалын нэгдсэн тендер зарлагдаж тендерт гэрээ байгуулсан эм ханган нийлүүлэх төвүүдээс эм боох материалд 84,123.4 мянган төгрөгийн эм боох материал авсан байна НИК –ийн дундад бүс Петровис ХХК-тай шууд гэрээ байгуулан 76,104.2 мянган төгрөгийн шатахуун тослох материал худалдан авсан байна. Хүнсний, барилга засвар, бусад хангамжийн материал, бичиг хэргийн материалыг шууд гэрээгээр худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 930,211.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,953.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 10,464.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 740,536.5 мянган төгрөгийн 35 гүйлгээг бүрэн мэдээлж, зарлагын 124,132.1 мянган төгрөгийн 11 гүйлгээ мэдээлэхээс 13,935.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”,

6.4.8-д “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 13,935.0 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, өмч, хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрүүдийг байршуулах талаар албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн хувьд ЭМД-ийн сангаас авлага 30,928.5 сая төгрөг эмийн болон ХАОТатвар, бусад бараа материалын өглөг 60,012.1 мянган төгрөг байгаа нь өглөг авлагын харьцаа алдагдсан байна. Энэ нь 2023 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлсэн төлбөрийн нэхэмлэхээс хяналт хийгдэн 46,471,9 мянган төгрөгийн хасагдал хийгдсэнтэй холбоотой өр үүссэн байна. Иймд үүссэн өглөгийг барагдуулах асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 19,000.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 19000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн залруулга

Бөмбөгөр сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 15/10 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр байгууллага орчны тохижилт 20.000.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд авах тогтоолыг хэрэгжүүлээгүй 19.000.0 мянган төгрөгийн нийтийн байгууламжийн ангилалд бүртгэх хөрөнгийг тусгай хэрэгсэлийн материалын дансанд орлого авсан ыг аудитын явцад бусад үндсэн хөрөнгийн дансанд залруулан тусгуулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалтыг хэрэгжүүлж тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж өгөв.

Аудитаар 2 зөрчил² илэрсэнд 2 албан шаардлага өгөв.

5.1 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 4906 м2 талбай бүхий газрыг 2005 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 22 дугаар захирамжаар олгосон байхад байгууллагын санхүүгийн тайланд 5253 м2-аар бүртгэснийг тулган шалгахад 337 м2 зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайланд биет бус хөрөнгөнд бүртгэлтэй газрын талбайн хэмжээ, гэрчилгээний талбайн хэмжээний зөрүүтэй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 13,935.0 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой гэрээг бүрэн байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлнэ гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бөмбөгөр сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 15/10 дугаар тогтоолоор ОНХСангийн санхүүжилтээр байгууллага орчны тохижилт 20.000.0 мянган төгрөгийн хөрөнгийг тусгай хэрэгсэлийн материалын дансанд орлого авсан	1	19000.0			1	19000.0	1	19000.0				
Дүн	1	19000.0			1	19000.0	1	19000.0				



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 4906 м2 талбай бүхий газрыг 2005 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 22 дугаар захирамжаар олгосон байхад байгууллагын санхүүгийн тайланд 5253 м2-аар бүртгэснийг тулган шалгахад 337 м2 зөрүүтэй	1				1		0	0
Нийт дүн	1				1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 13,935.0 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой гэрээг бүрэн байршуулаагүй байна.	1	13,935.0			1	13,935.0		
Дүн	1	13,935.0			1	13,935.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 2 сарын 22 өдөр

Дугаар 93/14210573/ БНА/2024
/149/НА-СТА-ТМЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 4906 м² талбай бүхий газрыг 2005 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 22 дугаар захирамжаар олгосон байхад байгууллагын санхүүгийн тайланд 5253 м²-аар бүртгэснийг тулган шалгахад 337 м² зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Байгууллагын санхүүгийн тайланд биет бус хөрөнгөнд бүртгэлтэй газрын талбайн хэмжээ, гэрчилгээний талбайн хэмжээний зөрүүтэй зөрчлийг арилган

5040182

арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн газрын дарга Д. Оюундалай, нягтлан бодогч Ж. Гандалай нарт даалгав^{2, 3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

 О. МАНДАХ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 107/14210573/БНА/2024
1149/НА - СТА - ДЦУЗ

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 13935000 төгрөгийн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлнэ гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


3040326

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг хүрээнд Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д. Оюундалай, нягтлан бодогч Ж. Гандалай нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТЫН ХХК-ийн
АУДИТОР:  О.МАНДАХ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно